Амны хаалт заавал зүүх захирамж

Захирамжийн утга

- ◆ Захирамж үйлчлэх хүрээ : Сөүл хотод оршин суугч, Сөүл хотод орж ирсэн бүх иргэд
- ◆ Захирамжийн агуулга : Байшин барилгын дотор, гадна орчинд амны хаалт зүүх
  ※ Гэртээ байхдаа, хоол идэхдээ амны хаалт зүүхгүй байж болно
- ◆ Захирамж хэрэгжих хугацаа : 2020.8.24.(Даваа) ~ чангатгасан дэглэмийн хугацаа дуусах хүртэл

☐ Захирамж гаргах болсон шалтгаан

○ Амны хаалтыг зөв хэрэглэсэнээр өөрийгөө болон бусад хүмүүс ийг халдвараас хамгаална.

– Амны хаалт хэрэглэсэнээр халдварын тархлалтыг 85% бууруулж чадна. ('20, Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүл THE LANCET)

※ Амны хаалт зүүгээгүй тохиолдолд 5-с их дахин халдвар авах магадлал өндөртэй.

Амны хаалт зүүснээр халдвараас хамгаалж чадсан жишээнүүд (Халдварт өвчин судлалын төв)
■ Халдвар авсан хүнтэй хамт машинд 1цаг орчим хамтдаа сууж явсан 3хүн бүгд : сөрөг
■ Халдвар авсан өвчтөнтэй 7хоног шууд харьцсан эмнэлэгийн 17ажилтан бүгд : сөрөг
■ 28хүн халдвар авсан кофешопын 4 ажилтан бүгд : сөрөг

☐ Захирамж үйлчлэх хүрээ : Сөүл хотод оршин суугч, Сөүл хотод орж ирсэн бүх иргэд

○ Сөүл хотод оршин суугч гэдэг нь Сөүл хотын харъяа оршин суугч.

Сөүл хотын харъяа иргэн бусад нутаг дэвсгэрт очсон тохиолдолд
■ Захирамжийн үйлчлэх хүрээ нь Сөүл хотод хамрах тул Сөүл хотын харъяа иргэн бусад нутаг дэвсгэрт очсон тохиолдолд энэхүү захирамж хэрэгжихгүй

○ Сөүл хотод орж ирсэн иргэн гэдэг нь Сөүл хотоос бусад нутаг дэвсгэрт оршин суугч Сөүл хотод ажилдаа ирэх, ажил эрхлэн явуулах, аялал жуулчлалаар ирсэн бүх хүмүүс.

☐ Захирамж үйлчлэх хүрээ : Сөүл дэх байшин барилгын дотор, гадна орчин

○ (Дотор орчин) Автобус, метро, усан онгоц, нисэх онгоц, бусад тээврийн хэрэгсэл дотор амны хаалт заавал зүүх

○ (Гадна орчин) Доорх газруудад амны хаалт заавал зүүнэ

– Цуглаан, уулзалт, ёслолын арга хэмжээ(соёл, урлаг), цуглаан хөдөлгөөнд бөөнөөр цугларах үед

Цуглаан, уулзалт, ёслолын арга хэмжээ/Хөдөлгөөн
■ (Цуглаан, уулзалт, ёслолын арга хэмжээ) Нэгдсэн зорилготой, урьдчилан төлөвлөсөн газар, нийтээр цугларан цуглаан·уулзалт·ёслолын үйл ажиллагаа явуулах үед
■ (Цуглаан) 「Цуглаан хөдөлгөөний тухай хууль」-н ёс горимыг дагуу зөвшөөрөгдсөн цуглаан·уулзалт·ёслолын арга хэмжээ

– Хамт нэг гэрт амьдарч байгаа · нэг гэр бүлээс бусад хүмүүстэй 2m зай барих боломжгүй бол

☐ Амны хаалт зүүх шаардлагагүй тохиолдолууд : Гэртээ байх үедээ болон хоол идэх үед амны хаалт зүүхгүй байж болно.

❶ Гэртээ байх үедээ

– Оршин суугаа газар(амьдарч байгаа гэртээ)

– Тусгаарлагдсан орон зайнд ганцаараа болон нэг гэрт хамт амьдардаг хүмүүстэй йгээ хамт байхдаа(гэр бүл)

※ Хамт нэг гэрт амьдардаг хүнээс бусад хүнтэй байх бол амны хаалт заавал зүүнэ

Машин(унаа)-д амны хаалт зүүх тухай
■ Машин(тээврийн унаа)нд ганцаараа эсвэл хамт амьдардаг гэр бүлийнхэнтэйгээ явж байгаа бол амны хаалт зүүх шаардлагагүй
■ Машин(тээврийн унаа)нд гэр бүлээс бусад хүнтэй хамт байх бол амны хаалт заавал зүүх

❷ Хоол идэх үедээ

※ Хоол идэхээс өмнө·хоол идсэний дараа амны хаалт заавал зүүх

– Хоол идэх(хоололт) хөнгөн зууш идэх үед

– Архи уух, тамхи татах, цай, кофе уух үед

❸ Бусад амны хаалт тайлахаас өөр аргагүй тохиолдолууд

※ ②~⑤ –н хувьд тухайн үйл хөдөлгөөн эхлэхийн өмнө·хойно амны хаалт заавал зүүнэ

① Амны хаалт зүүсэн үед амьсгал давхцаж биеийн байдал хүндрэх бол

- 24сараас бага насны хүүхэд
- Хүнд өвчтөн
- Амьсгалын замын архаг өвчтөн амны хаалт зүүснээр амьсгалахад хүндрэлтэйбол

② Эмчилгээ·эрүүл ахуйн холбогдох ажил хийхэд амны хаалт тайлахаас өөр аргагүй тохиолдол

- Амны хаалтыг тайлж эмчилгээ·үзлэг·оношлогоо зэрэг шаардлагатай үед
- Усанд орох, нүүрээ угаах , шүдээ угаах үед

③ Төрийн албан ёсны ажлын үед

- Засгийн газар·орон нутгийн засаг захиргааны ажил·дипломат ажил, үндэсний батлан хамгаалалт, мөрдөн байцаалт, тусламж, төрийн олон нийтийн албан ажлын үед амны хаалт тайлахаас өөр аргагүй тохиолдолд
- Засгийн газар·орон нутгийн засаг захиргааны ажил·төрийн лон нийтийн албан ажил дээр тайлан тавих, мэдэгдэл гаргах үед
- Засгийн газар·орон нутгийн засаг захиргааны ажил·төрийн лон нийтийн албанд зураг (цээж зураг·паспортны зураг зэрэг)өгөх шаардлагаар зургаа авахуулах үед
- Засгийн газар·орон нутгийн засаг захиргааны газраас заагдсан журмын дагуу багш, лекторууд онлайн сургалт явуулах үед

④ Амны хаалт тайлж ажил хийхээс өөр аргагүй тохиолдол

- Мэргэжлийн дуучин·жүжигчин·дуурийн дуучин·нэвтрүүлэгч·загвар өмсөгч·урлагийн ажилтан зураг авахуулах, бичлэг хийлгэх болон тоглолтын үед
- Мэргэжлийн тамирчин тэмцээнийүед
- Мэргэжлийн хөгжимчид тайзнд тоглолт хийх үед

⑤ Бусад тохиолдол

- Сэлэх, усанд тоглох үед

※ Дээрх тохиолдолуудад халуурах, амьсгалын замын өвчнийшинж тэмдэг илрэх бол амны хаалтыг заавал зүүх шаардлагатай

❑ Амны хаалтны стандарт

○ Амны хаалтны төрөл

– Эмчилгээ, мэс заслын зориулалтын амны хаалт, шүүлтүүртэй амны хаалт, да авуун амны хаалт

– Хүнс, эм эмэн бүтээгдхүүний аюулгүй байдлын хяналтын газраас хүлээн зөвшөөрөгдсөн амны хаалтыг хэрэглэхийг зөвлөж байна

Хүнс, эм эмэн бүтээгдхүүний аюулгүй байдлын хяналтын газраас хүлээн зөвшөөрөгдсөн амны хаалт
▪KF94 амны хаалт : Корона19 халдвар авсан магадлалтай хүнийг асарч байгаа бол зүүнэ
▪KF80 амны хаалт
– Ханиалгах, хоолой өвдөх зэрэг амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн бол зүүнэ
– Сул дорой биетэй болон архаг өвчтэй хүнтэй ойртох үед зүүнэ
* Сул дорой биетэй хүн : Өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн эх, хууч өвчтөн
** Архаг өвчтэй хүн : Уушигны архаг өвчин, чихрийн шижин, бөөрний архаг өвчин, элэгний архаг өвчин, зүрх судасны архаг өвчин, хорт хавдартай өвчтөн
▪Шүүлтүүртэй·мэс заслын амны хаалт
– Урт цагаар удаан нэг газар байх үед /бүгчим халуун өдөр / амьсгалахад хэцүү үед зүүнэ

○ Амны хаалтыг зөв хэрэглэх заавар

– Нүүрний хэлбэрт тохирсон амны хаалтыг сонгож ам, хамраа бүтэн таглан амны хаалтыг зүүнэ

※ Ам, хамраа таглахгүйгээр амны хаалт зүүсэн тохиолдолд амны хаалт зүүгээгүйтэй адил.

< Хавсралт 2 >

Амны хаалт заавал зүүх захирамжтай холбогдсон Q&A

※ Коронавирус-19 эмнэлзүйн онцлог, шинж хараахан тодорхой бус боловч ойрын үед өөрчлөгдөх магадлалтай байна. '20.8 сарын засгийн газраас гаргасан удирдамж, эрдэм шинжилгээний бага хуулын шийдвэрээс үндэслэсэн хариу болно.

Ⅰ.Амны хаалт зүүх тухай

Q1. Гэртээ амны хаалт заавал зүүх үү?

○ Гэртээ байхдаа амны хаалт зүүх шаардлагагүй.

○ Хэрэв гэр бүлийн хэн нэгэн гишүүн халуурах буюу амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд амны хаалтыг заавал зүүх шаардлагатай.

Q2. Бага насны хүүхэд амны хаалт заавал зүүх шаардлагатай юу?

○ 24сараас бага настай хүүхдийн хувьд амьсгалын тогтолцоо бүрэн хөгжөөгүйгээс үүдэн амьсгал давчдах үед амны хаалтаа өөрөө тайлж чадахгүй тул амны хаалт заавал зүүх захирамжийн үйлчлэх хүрээнд хамрагдахгүй

○ Халдварт өвчний тархлалтаас хамгаалан, бага насны хүүхэд амны хаалт зүүх үед анхааралаа хандуулахыг зөвлөж байна

Q3. Эмнэлэгт хэвтсэн өвчтөн амны хаалтыг заавал зүүх ёстой юу?

○ Архаг өвчтөн амны хаалт зүүсэн үед амьсгалахад хүндрэлтэй бол амны хаалтыг зүүхгүй байж болно

○ Амны хаалт зүүхэд амьсгалах хүндрэлтэй өвчтөний хувьд эмчийн зааврын дагуу амны хаалт зүүхгүй байж болно

Q4. Шүдний эмнэлэгт эмчилгээ хийлгэхдээ заавал амны хаалт зүүх үү?

○ Шүд, чих хамар хоолойн эмчилгээ хийлгэх тохиолдолд амны хаалтаа тайлж эмчилгээ хийлгэх шаардлагатай тул амны хаалт зүүхгүй байж болно

○ Харин, эмчилгээний өмнө·эмчилгээний дараа амны хаалт заавал зүүх ёстой

Q5. Албан газар шүдээ угаахдаа амны хаалт заавал зүүх шаардлагатай юу?

○ Усанд орох, нүүрээ угаах, шүдээ угаах үедээ амны хаалт зүүх шаардлагагүй

○ Харин өмнө·дараа амны хаалтыг заавал зүүнэ

Q6. TV зэрэг нэвтрүүлэгт оролцож байгаа хүмүүс яагаад амны хаалт зүүдэггүй вэ?

○ Мэргэжлийн дуучин·жүжигчин·дуурийн дуучин·нэвтрүүлэгч·загвар өмсөгч·урлагийн ажилтан зураг авахуулах, бичлэг хийлгэх болон тоглолтын үед амны хаалт зүүхгүй байж болно

○ Харин, бичлэгийн өмнө·дараа амны хаалт заавал зүүх, нэвтрүүлэгт оролцож байгаа дээрх хүмүүсээс бусад хүмүүс амны хаалт заавал зүүх шаардлагатай

Q7. Засгийн газрын ажилтан, төрийн албан ажилтан мэдэгдэл хийхдээ амны хаалт зүүдэггүй вэ?

○ Засгийн газар·орон нутгийн засаг захиргааны ажил·дипломат ажил, үндэсний баталгаалалт, мөрдөн байцаалт, тусламж, төрийн олон нийтийн албан ажлын үед амны хаалт тайлахаас өөр аргагүй тохиолдолд амны хаалт зүүхгүй байж болно.

○ Ард иргэдэд яаралтай мэдэгдэл хийх·төрийн албан мэдээлэлийг зөв хүргэхийн үүднээс амны хаалт зүүхгүй байж болно,
Харин, мэдэгдэл хийхийн өмнө·дараа заавал амны хаалт зүүх, хамт байгаа албаны ажилтад бүгд амны хаалт зүүх

Q8. Зураг авахуулахдаа амны хаалт заавал зүүх ёстой юу?

○ Хувиараа зургаа авахуулах үед амны хаалтыг заавал зүүнэ. Харин цээж зураг, пасп ортны зураг г.м орон нутгийн засаг захиргаанд зураг өгөх шаардлага гарсан бол а мны хаалт зүүхгүй зураг авахуулж болно

○ Тасалгаанд бусад хүмүүстэй 2м зай барьж харьцах, ганцаараа болон хамт явж байг аа гэр бүлийн хүнээс өөр хүнгүй бол амны хаалтаа тайлж болно

Q9. Тамирчид яагаад амны хаалт зүүхгүй байгаа вэ?

○ Мэргэжлийн тамирчдын хувьд амны хаалтаа тайлж тэмцээнд оролцохоос өөр аргаг үй тул амны хаалт зүүхгүй байж болно

○ Харин, тэмцээн эхлэхийн өмнө халуун·амьсгалын замын өвчний шинж тэмдэгийг шал гасаны дараа тэмцээнд орно. Тэмцээн эхлэхийн өмнө·дараа амны хаалтыг заавал з үүх шаардлагатай. Тэмцээнд оролцож байгаа тамирчдаас бусад хүмүүс бүгд амны хаалт зүүнэ

Q10. Юутүүб зохиогчид сувагтаа амны хаалт заавал зүүх ёстойюу?

○ Юутүүб зохиогчид нь амны хаалт заавал зүүх ёстой. Харин гэртээ болон тусгаарла сан газар ганцаараа бичлэг хийх тохиолдолд эсвэл гэр бүлийнхээ хамт бичлэг хий х бол амны хаалт зүүхгүй байж болно

○ Тасалгаан дотор бусадтай 2m зай барих, гэр бүлийн хүнээс бусад хүнгүй бол амны хаалт зүүх бичлэг хийж болно

Q11. Усан парк, гол дээр тоглоход амны хаалт заавал зүүх үү?

○ Нийгэмд зай барих 2-с дээш шатлалын үед халдварын эрсдэл өндөр тул усан парк ийн үйл ажиллагаа, голонд тоглохийг хориглосон

○ Харин, аргагүй эрхэнд усанд сэлэх, усанд тоглох бол амны хаалтаа тайлж болно. У санд орохоос өмнө·дараа амны хаалт заавал зүүх ёстой

Q12. Тамхи татахдаа амны хаалт зүүхгүй байж болно биз дээ?

○ Хоол идэхдээ адил амны хаалт зүүгүй байж болно.

○ Амны хаалтаа тайлж тамхи татах үед Корона19 халдвар авах эрсдэл өндөр тул та мхинаас гарахыг зөвлөж байна

○ Аргагүй эрхэнд тамхи татах бол бусадтай зайгаа барих, ярьж хөөрөхдөө хорио цээ рийн дэглэмийг мөрдөх шаардлагатай

Q13. Ууланд аялах, салхинд гарах, ил задгай газар биеийн тамирын дасгал хийхдээ а мны хаалт заавал зүүх ёстой юу?

○ Ууланд аялах,салхинд гарах, ил задгай газар биеийн тамирын дасгал хийх дээ буса д хүнээс 2m зайбарих боломжгүйтохиолдолд амны хаалтыг заавал зүүнэ

Q14. Ажлын байранд ажлаа хийхдээ амны хаалт зүүх ёстой юу?

○ Тусгаарласан орчинд ганцаараа ажил хийхдээ, ганцаараа хоол идэхээс бусад үед а мны хаалтыг заавал зүүнэ

Q. Ганц хүний ажлын байранд ч амны хаалт зүүх ёстой юу?

○ Ажлын байранд ганцаараа буюу гэр бүлийнхээ хамт байгаа тохиолдолд амны хаалт зүүхгүй байж болно

○ Харин, бусад хүн гаднаас ирэх тохиолдолд заавал амны хаалт зүүж харьцана.

Q15. Хамраа таглахгүй амаа зөвхөн таглаж амны хаалт зүүсэн бол захирамжийг зөрч сөнд тооцох уу?

○ Амны хаалтыг хамраа таглахгүйгээр эрүүндээ зүүж амаа зөвхөн тагласан тохиолдо лд халдварт өвчнөөс сэргийлж чадахгүй.

○ Ам, хамраа таглахгүй зүүсэн бол амны хаалт зүүгээгүйтэй адил.

Q16. Хоолны газар болон кофены газар амны хаалт заавал зүүх үү?

○ Кофе болон хоолны газар хоол идэхээс бусад үед амны хаалт заавал зүүнэ,
Хоол идэхээс өмнө·хоол идсэний дараа амны хаалт заавал зүүх ёстой

※ 2020.8.30.-с эхлэн нийгэмд зай барих 2-р шатлалд халдвар хамгаалалын дэглэмийг ча нгатгасантай холбогдуулан кофе, хоолны газар хоол идэхийг хориглосон.

○ Амны хаалтаа түр тайлахдаа, бохирдохоос сэргийлэн цэвэрхэн хялгар уутанд хийж хадгалахыг зөвлөж байна

Q17. Караоке-д дуу дуулахдаа амны хаалт заавал зүүх үү?

○ Караоке нь халдварын хамгийн эрсдэлтэй 3 орчин(битүү·ойр·шигүү) бүрдсэн газар т ул хорио цээрийн үед аль болох очихгүй байхыг зөвлөж байна

※ 2020.8.19.-с мөрдөж эхэлсэн нийгэмд зай барих 2-р шатлалийн журамд караоке-д о рохыг хориглосон

○ Аргагүй тохиолдолд караокед орсон бол дуу дуулах үедээ ч амны хаалтыг заавал зүүнэ

Q18. Даавуун амны хаалт зөвшөөрөгдсөн амны хаалтанд тооцогдох уу?

○ Хүнс, эм эмэн бүтээгдхүүний аюулгүй байдлын хяналтын газраас зөвшөөрөгдсөн то осонцор болон халдварын эрсдэл бага эмчилгээ, мэс заслын зориулалтын амны ха алт зүүхийг зөвлөж байна

○ Харин, дээр дурдсан амны хаалтыг худалдан авах боломжгүй бол даавуун амны ха алтыг угааж хэрэглэж болно

Q19. Торон амны хаалт зөвшөөрөгдсөн амны хаалтанд тооцогдох уу ?

○ Эмчилгээ, мэс заслын зориулалтын амны хаалт(дентал), фильтртэй амны хаалт, даа вуун амны хаалтыг зөвшөөрөгдсөн амны хаалтанд тооцно

○ Үүнээс бусад торон амны хаалт г.м халдвараас хамгаалах боломжгүй амны хаалты г зүүхийг зөвшөөрөхгүй

Q20. Гэрлэх ёслолын газар амны хаалтыг хэрхэн зүүх вэ?

○ Гэрлэх ёслолын газар ирсэн бүх хүмүүс амны хаалт заавал зүүнэ

○ Харин, гэрлэх ёслолын газарт нийгэмд зай барих журмыг даган мөрдөнө. (Эмэгтэйчүү д гэр бүлийн яам Гэр бүлийн соёлын хэлтэс-2544), Гэрлэж байгаа хосуудын хувьд гэрлэх ёсло лын газар амны хаалт зүүхгүй байж болно

※ Цугларсан зочид хамтдаа зураг авахуулах үед амны хаалт заавал зүүх, бичлэгийн үед гэрлэж бай гаа хосууд, хоёр талын аав ээжүүд зөвхөн амны хаалт зүүхгүй байж болно

Ⅱ. Удирдлагын арга хэмжээ

Q1. Захирамж хэрэгжих хугацаа удааширах уу?

○ Захирамжийг зөрчсөн тохиолдолд ногдох торгуулийн арга хэмжээний тухай 「Халдва рт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах тухай хууль」,"83-р зүйлийн 4-н агуулгыг 8.12 нд дахин шинэчилж 10.13 -с эхлэн хэрэгжүүлж эхлэнэ.

○ Үүнээс шалтгаалан хууль хэрэгжиж эхлэх хүртэл дээрх хуулийн торгуулийн арга хэм жээ ногдуулах боломжгүйгээс үүдэн удирдлагын зохих арга хэмжээ ногдуулно

※ Олон нийтийн тээврийн хэрэгсэлээр зорчихдоо амны хаалтыг зүүх журам (5.13~)наас эхлэн хэрэгжиж эх элсэн бөгөөд, метрон дотор амны хаалт зүүгээгүй тохиолдолд 250,000воноос 1сая воны торгууль ногду улна. Халдварын эрсдэл өндөртэй газруудад бөөнөөр цугларах үед (8.19~)-с эхлэн амны хаалт зүүх жу рмыг зөрчсөн тохиолдолд 3сая воны торгууль ногдуулна.

○ Харин, захирамжийн хэрэгжих хугацаанд журам зөрчсөн тохиолдолд эмчилгээ·үзлэг·б айцаалтнд зарцуулагдсан төлбөрийг нөхөн төлүүлэн удирдлагын зохих арга хэмжээ а вна.

Q2. Амны хаалтыг заавал зүүх захирамж хэзээ хүртэл хэрэгжих вэ?

○ Одоогийн байдлаар мөрдөж байгаа нийгэмд зай барих 2-р шатлалын дэглэмээс 1-р шатлалд шилжих тохиолдолд тус захирамжийн хэрэгжих хугацаа дуусгавар болно

○ Захирамж хэрэгжих хугацаа дууссан ч гэсэн ‘Ахуй амьдралдаа зай барих’ дэглэми йн дагуу амны хаалтыг байнга зүүхийг зөвлөж байна

Q3. Сөүл хотоос бусад нутаг дэвсгэрт оршин суугч Сөүл хотод амны хаалт зүүгээгүйт охиолдолд амны хаалт зүүх захирамжийн хариуцлага хүлээх үү ?

○ Сөүл хотын захирамжнд дурдсаны дагуу Сөүл хотод орж ирсэн бусад нутаг дэвсгэрт оршин суугч нь захирамжийн үйлчлэх хүрээнд хамрах тул захирамжийн дагуу зохих арга хэмжээг авна.

Q4. Амны хаалт зүүх захирамжийг зөрчсөн тохиолдолд хуулийн ямар арга авах вэ?

○ 「Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах тухайхууль」-н 49-р зүйлийн 1.2.ийн 4-т

заагдсаны дагуу арга хэмжээ авах, түүнчлэн тус хуулийн 83-р зүйлийн 4-т заагдсан ы дагуу 100,000воны торгууль ногдуулан, зөрчсөнөөс үүдсэн эмчилгээний зардал·үз лэг·байцаалт·ариутгалын зардалыг хувь хүнээр нөхөн төлүүлнэ.

○ Торгуулийн төлбөрийг 2020.10.12.хүртэл төлнө. Торгууль төлөх хугацааг хэтрүүлсэн т охиолдолд зохих арга хэмжээ авна

※ Олон нийтийн тээврийн хэрэгсэлээр зорчихдоо амны хаалтыг зүүх журам (5.13~)наас эхлэн хэрэгжиж эх элсэн бөгөөд, метрон дотор амны хаалт зүүгээгүй тохиолдолд 250,000воноос 1сая воны торгууль ногду улна. Халдварын эрсдэл өндөртэй газруудад бөөнөөр цугларах үед (8.19~)-с эхлэн амны хаалт зүүх жу рмыг зөрчсөн тохиолдолд 3сая воны торгууль ногдуулна.

Q5. Шалгалт хэзээнээс эхлэж явагдах вэ?

○ Одоогийн байдлаар халдварын эрсдэл өндөр газруудаар шалгалт хийгдэж, захирам жийн арга хэмжээг авч байна.

○ Цаашид шалгалтанд хамрах газруудыг өргөтгөн байнгын хяналтын арга хэмжээг ав ахаар бэлтгэж байна

Q6. Амны хаалт зүүх захирамжийг зөрчсөн зөрчлийг хаана, хэрхэн мэдэгдэх вэ?

○ Захирамж хэрэгжих хугацаанд зөрчил хүлээн авах тогтсон газар одоогий байдлаар байхгүй байгаа, иргэд хоорондын мэдээлэлийг ашиглан зөрчлийг илрүүлж байгаа болн о

○ Захирамж хэрэгжих хугацаа дуусахаас өмнө зөрчил хүлээн авах газрыг тогтоож мэ дэгдэл хийнэ

Q7. Албан газар дээр ажилтнууд амны хаалт зүүгээгүй, эсвэл зөв зүүгээгүй бол туха йн албан газар хариуцлага хүлээх үү ?

○ Зөрчсөн хувь хүнд торгуулийн арга хэмжээ авна

○ Харин албан газар нь ажилтнуудаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хорио ц ээрийн дүрмийг даган мөрдөх арга хэмжээг чанд хэрэгжүүлэх шаардлагатай